

Авлигын шалтгаан, үр дагавар


© Авлигатай тэмцэх газар, 2018 он



“Байгалийн гамшигт их өртдөг муж улсуудад авлига их байна”

Эх сурвалж: Weathering Corruption, Peter T. Leeson, Russell S. Sobel, Journal of Law and Economics, vol. 51, (November 2008), холбоос:

http://www.peterleeson.com/Weathering_Corruption.pdf





- “Авлигач зан үйлийн маш олон төрөл, хэлбэр байдаг учраас авлигыг нөхцөлдүүлж байгаа олон хүчин зүйлүүд байна.... Тиймээс авлигын учир шалтгааныг тоймгүй олон удаа тайлбарлах гэж оролдсон бөгөөд тэдгээр тайлбар, тодорхойлолтыг системтэй байдлаар ангилж ялгах нь туйлын түвэгтэй байдаг”
- Жералд Е.Кайден



- Corruption thrives on darkness and invisibility. It is anonymous and unmeasurable. It is rooted in the very human vices of greed and lust for power... [It] is colorless, shapeless, odorless, collusive, secret, stealthy, shameless... It often leaves no trail but that impressed in human minds, memories and perceptions.
- Jim Wesberry




- “Аливаа улсын нийтийн албан дахь авлига болон ашиглан шамшигдуулах хэргийн шалтгааныг тайлбарлахад нийгэм, эдийн засаг, улс төр, байгууллага болон хувь хүнтэй холбоотой хүчин зүйлүүдийг нийлмэл цогц байдлаар авч үзэх нь чухал болохыг судалгаа харуулдаг”
- С.Фижно (Хейденхеймер, Жонстон ба Ливайн, Хейвүүд, Клитгаард, Күүпер)



Олон түмний сонголтын онол

- Авлигыг макро болон микро түвшинд, шалтгааныг хувь хүний түвшинд авч үздэг.
- Тухайн нөхцөлд тохирсон үндэслэл бүхий шийдвэр гаргаж урьдчилан таамагласан үр дүнг бий болгодог



Ялзарсан алимны онол

- Авлига, түүний шалтгааныг хувь хүний түвшинд
- Сөрөг зан үйл нь авлигыг бий болгодог



Байгууллагын соёлын онол

- Авлига, түүний шалтгааныг байгууллагын түвшинд
- Байгууллага, хамт олон, бүлгийн дотор тогтсон хэм хэмжээ нь ухамсар, зан үйлийн хэм хэмжээг бий болгож, улмаар авлигыг бий болгодог



Ёс суртахууны үнэт зүйлийн зөрчилдөөний онол

- Авлига, түүний шалтгааныг нийгмийн түвшинд
- Нийгмийн тодорхой үнэт зүйл, хэм хэмжээ нь хувь хүний үнэт зүйл, хэм хэмжээнд нөлөөлж, улмаар албан тушаалтнуудын зан үйл, ёс суртахуунд нөлөөлдөг



Төрийн удирдлагын чиг баримжааны онол


- Авлига, түүний шалтгааныг нийгмийн болон байгууллагын түвшинд
- Нийгмийн дарамт: зөвхөн чиг үүргээ гүйцэтгэхэд анхаарснаас шударга, ёс зүйтэй байдал алдагдаж, улмаар авлигад автдаг



Харилцан хамаарлын онол

- Бүх түвшинд
- Учир шалтгааны тодорхой загвар байхгүй, зөвхөн харилцан хамааралтай гэж үздэг.

Авлигын шалтгаан (Клитгаард, 1988)



M – monopoly (эрх дарх, ноёрхол)


D – discretion (үйл ажиллагааны эрх чөлөө)

A – accountability (хариуцлага)

Авлигын нөхцөл шалтгаан (Becker, Ehrlich, 1972)




Авлигын нөхцөл шалтгаан




Авлигын шалтгаан нөхцөл (USAID)



Авлигын шалтгаан нөхцөл



Авлигын нөхцөл байдал улс орон бүрээр
ялгаатай. Тиймээс шалтгаан нь мөн янз бүр байж
болно.



Швед: 2016 АТИ: 88 (100), байр 4 (176)

Онцлог: Орон нутгийн эрх мэдэл өндөр, хяналт сул

- 21 ландстинг, 290 коммунер. Орон нутагт хөрөнгө зарцуулах эрх мэдэл төвлөрдөг.
- Нийтийн алба нь жил бүр 500 тэрбум кронор буюу 62.5 тэрбум ам.доллар хэмжээтэй ажил, үйлчилгээ худалдан авдаг. Үүнээс 100 тэрбум кронор буюу 12.5 тэрбум ам.долларын ажил, үйлчилгээг шууд худалдан авдаг.
- Хэрэв үр дүнтэй, шударга өрсөлдөөн бүхий тендер явуулж чадвал 20 тэрбум кронор буюу 2.5 тэрбум ам.доллар хэмнэх боломжтой гэсэн тооцоо хийсэн.
- Худалдан авах ажиллагаатай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан нь холбогдох дүрэм, журмыг оролцогчид сайн мэддэггүй, ямар үйлдэл нь авлига болох талаар ойлголт муутай, мөн фаворитизм, непотизмтой холбоотой.


Эх сурвалж: Нуугдмал авлига: Авлигаас ангид улс дахь төөрөгдөл. Холбоос: <http://www.mollwenden.se/en/articles/hidden-corruption-the-illusion-of-the-corruption-free-country/>

Япон: 2016 онд АТИ: 72, байр: 20

Онцлог: "Төмөр гурвалжин"

Кансей данго
(улс төрийн санхүүжилт авах)

Амакудари
(өндөр цалинтай ажилд орох)



Өмнөд Солонгос: 2016 оны АТИ: 53, байр: 52
Онцлог: Корпорацийн дээд түвшинд “ах захаа хүндлэх хүндлэл” хатуу
ТОГТСОН.



Хятад: 2016 оны АТИ: 40, байр: 79


Онцлог: “Гуанши” хэм хэмжээ, асар их байгалийн нөөц баялаг, төрийн өмчит компани,
орон нутгийн эрх мэдэл их.



Перу: 2016 оны АТИ: 35, байр: 101
Онцлог: Хууль зөрчих нь хууль сахин биелүүлэхээс “хямд”,
авлигын тогтолцоо нь задарч, сегментчлэгдэж байгаа.





Азербайжан: 2016 АТи: 30, байр: 123
Онцлог: дангаар ноёрхох дэглэм бүх нөөцийг төвлөрүүлж атгасан



**Тогтолцоогоо тогтоон барих, дотооддоо
хяналт тавих, гадаадад нэр хүндээ хамгаалах**

THE FIRST FAMILY'S STAKE IN AZERBAIJAN'S GOLD FIELDS



МОНГОЛ ДАХЬ АВЛИГЫН ШАЛТГААН



Эдийн засгийн
зарим салбар
дахь
хөнгөлөлт,
урамшуулал

Байгалийн
нөөц
баялагийн
ашиглалт


Үнийн хяналт

**ЭДИЙН
ЗАСГИЙН ХҮЧИН
ЗҮЙЛҮҮД**

Эдийн засаг
дахь төрийн
оролцоо

Орлогын ялгаа

Инфляци





Ядуурал

Байгалийн
нөөц баялаг

Ажилгүйдэл

**НИЙГЭМ,
СОЁЛЫН
ХУЧИН
ЗҮЙЛҮҮД**

Үнэт зүйлийн
чиг
баримжаа

Боловсролын
тогтолцоо

Түүхэн хүчин
зүйл

Макро түвшинд


Месо түвшинд

Төрийн албаны стандарт байхгүй
Ил тод бус
Хяналт сул
Хариуцлагын тогтолцоо сул
Удирдлагын манлайлал байхгүй
Тэгш бус байдал

Микро түвшинд

Монгол:

- Макро түвшинд: Үндэсний хэмжээний үлгэр жишээ удирдагч байхгүй, хөгжлийн нэгдсэн бодлого байхгүй, гаднын нөлөөлөл өндөр
- Месо түвшинд: Төрийн албаны стандарт байхгүй, хяналт сул, хариуцлагын тогтолцоо хөгжөөгүй
- Микро түвшинд: хамтран амьдрах сэтгэлгээ төлөвшөөгүй, хувиа бодсон зан чанар давамгайлсан, зөвхөн ашиг хонжоо хардаг, бүхнийг амар хялбар аргаар гүйцэлдүүлэх сэтгэлгээ, бусдыг эрх ашгийг үл хүндэтгэдэг



Гарз хохирол, үр дагавар



Тендер-авлига-улс төр

Унгарын жишээ

- 630 сая еврогийн авто замын төсөл
- Оролцогч компаниуд хоорондоо урьдчилан тохирч хэн нь тендер авахаа шийдсэн ба бусад компанидаа ажил хуваахаар тохирсон
- Эндээс олсон ашгийн нилээд хувь нь улс төрийн намын санхүүжилтэнд зарцуулагдсан
- 27.7 сая еврогийн торгууль ногдуулсан

Эх сурвалж: OECD (2010), "Policy roundtables. Collusion and Corruption in Public Procurement", OECD Publishing

Тендер – авлига – улс төр

Францын жишээ

- Барилгын компаниуд: Bouygues (Буйг), Suez-Lyonnaise, Vivendi
- 1989-1996 онд Ile-de-France мужийн хэмжээнд сургууль барих 4 тэрбум еврогийн төсөл
- Le Monde сонин энэ явдлыг “нийтийн хөрөнгийг завшихын тулд үгсэн тохиролцсон хуйвалдаан” гэж нэрлэсэн
- Нийт өртгийн 2 хувийг тухайн мужид идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг улс төрийн дөрвөн намд санхүүжилт болгож өгсөн
- Авлига, хээл хахууль, шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаа, хууль бусаар давуу тал олгосон хэргээр Jacques Durand ял шийтгүүлсэн.

□ Эх сурвалж:

- <http://www.againstcorruption.org/bribery.asp?id=726>
- OECD (2010), “Policy roundtables. Collusion and Corruption in Public Procurement”, OECD Publishing

Японы жишээ: Кансэй-данго, амакударари

- Хохирлын хэмжээ: **23.5 тэрбум иен** (комиссын тооцоолсноор, зөвхөн 2003-2004 оны)
- 2005 онд Худалдааны шударга байдлын комиссоос 45 компанид үгсэн хуйвалдах үйл ажиллагаагаа зогсоохыг тушаасан.
- 1999-2004 оны хооронд Японы Хурдны замын корпорациас зарласан тендерийн 70 гаран хувийг 47 компани авсан бөгөөд эдгээр компаниуд нь 2 нууц бүлэглэлд хамрагдаж байв.
- А-кай буюу А ассоциацад 17 компани, К-кай буюу К ассоциацид 30 компани
- 2003-2004 оны хооронд 126.8 тэрбум иений 96 төслийг эдгээр компаниуд авсан
- 20 орчим төрийн албан тушаалтан, үүн дотор Japan Highway-ийн захирал
- Зам барилгын асуудал хариуцсан төрийн байгууллагад ажиллаж байсан хүмүүсийн 60 хувь нь тэтгэвэрт гараад энэ салбарын компаниудад ажилд орсон (amakudari)

Эх сурвалж:

- OECD (2010), "Policy roundtables. Collusion and Corruption in Public Procurement", OECD Publishing
<http://www.japantimes.co.jp/news/2005/06/30/national/bid-rigging-probe-targets-highway-body/>

Бангладешийн жишээ: Падма гүүр

- Дэлхийн банк **2.1 тэрбум** долларын санхүүжилтийг цуцалсан
- Падма гүүр – Бангладешийн түүхэн дэх хамгийн том бүтээн байгуулалт
- Дэлхийн Банкны мэдээллийн дагуу Бангладешийн Авлигатай тэмцэх комисс эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан
- 7 хүн, үүнд SNC-Lavalin компанийн 4 ажилтан холбогдсон
- Дэлхийн банк төслөөс татгалзсаны дараа бусад санхүүжүүлэгчид болох ЖАЙКА, Азийн хөгжлийн банк, Исламын хөгжлийн банк мөн татгалзсан.
- Бангладешийн Засгийн газар өөрөө санхүүжилтээ гаргахаар болсон байна.
- Төслийн одоогийн өртөг 3 тэрбум ам.доллар

Эх сурвалж:

- Transparency International (2014), Curbing Corruption in Public Procurement. A Practical guide.
- Дэлхийн банк. Падма гүүрийн төслийн талаархи хөндлөнгийн шинжээчдийн эцсийн дүгнэлт. 2013.2.20
<http://progressbangladesh.com/padma-scandal-world-bank-publishes-final-reports-of-external-panel/>
- <http://www.dhakatribune.com/bangladesh/2015/jan/02/padma-bridge-project-well-track>

ТЗҮӨ

SNC-Lavalin International

- Монреалд төвтэй Канадын инженеринг компанийн салбар
- Хээл хахуульд зориулсан нууц данстай байсан
- PCC- project consultancy costs or project commercial cost
- ТЗҮӨ – төслийн зөвлөх үйлчилгээний өртөг эсвэл төслийн арилжааны өртөг гэж нэрлэж байсан
- 2008- 2011 оны хооронд 13 төсөл дээр ашигласан
- Нигериа, Замби, Уганда, Гана, Энэтхэг, Казакстан, Бангладеш, Камбож
- 2013 онд Дэлхийн банкнаас тус компани SNC-Lavalin Inc. болон түүний 100 салбар болон охин компанийг 10 жилийн хугацаагаар төсөлд оролцох эрхийг хаасан.

□ Эх сурвалж: http://www.huffingtonpost.ca/2013/05/15/snc-lavalin-international_n_3277347.html

“Ghost” schools

Пакистаны жишээ

- Нийт 163 000 сургууль байдаг. /холбооны төсөв ба мужийн төсөв/
- Пакистаны Засгийн газраас холбооны хэмжээний 13 094 сургуулийн зардалд 8 тэрбум рупи буюу ойролцоогоор 80 сая ам.доллар зарцуулдаг.
- 8 000 гаран сургууль зөвхөн цаасан дээр байдаг
- Нилээд олон нь нийслэл Исламабад хотод бүртгэлтэй
- Синдх мужид 48 227 сургууль бүртгэгдсэнээс 4 540 нь хангамжгүй, 6 480 /2009 он/ нь цаасан дээр, 524 нь хувийн юм шиг байдаг.
- Улсын хэмжээгээр 5.5 сая хүүхэд сургууль завсардсан нь дэлхийд Нигерийн дараа 2-т ордог.
- Бичиг үсэгт тайлагдсан байдал 46 хувь, эмэгтэйчүүд 26 хувь /Пакистаны Боловсролын яамны мэдээ/
- Бусад эх сурвалж энэ тоог 26 хувь ба 12 хувь гэж үздэг. Гэхдээ гарын үсгээ зурах хэмжээний бол бичиг үсэгт тайлагдсан гэж тооцох бол.

Эх сурвалж:

- <http://blog.transparency.org/2014/12/16/corruptions-effects-on-education-in-pakistan/>
- http://www.unesco.org/education/efa/know_sharing/grassroots_stories/pakistan_2.shtml

Ямаа ба хашаа



- Дэлхийн Банкны 12.6 сая долларын төслөөр Баруун Африкт техникийн сургалтын төв баригдсан
 - 250 мянган ам.долларын хашаа барих шаардлагатай гэж төслийн захирал үзсэн /нутгийн иргэд ба тэдний ямаанаас хамгаалах/
 - Дутуу баригдсан хашааг бодитоор бол 75 000 доллараар барьсан тооцоо гарсан
 - 175 000 доллар хаашаа ч юм алга болсон
 - Ямаанууд чөлөөтэй зугаалсан хэвээр үлдсэн
- Эх сурвалж: Транспаренси Интернешнл, 2013 он, Дэлхийн авлигын тайлан. Боловсролын салбар.

Сум (үл) нэвтрэх хантааз

Өмнөд Солонгосын жишээ

- 2010 онд Өмнөд Солонгосын армийн тусгай хүчний цэргүүдэд зориулан 2000 сум үл нэвтрэх хантааз худалдан авсан
 - Хойд Солонгосын зэвсэглэлд байдаг АК-47 буугаар туршилт хийхэд сумыг хааж чадаагүй
 - Мөрний хэсэг нь тохиромжтой байрлалд зогсож буудалт хийх боломжгүй
 - Хурдан хугацаанд өмсөх, тайлахад хүндрэлтэй
- Армийн хангалтын газрын захирал нь анх худалдан авах үед хийгдсэн туршилтын үр дүнг өөрчилсөн байсан.

Эх сурвалж:

<http://english.yonhapnews.co.kr/news/2015/02/25/91/0200000000AEN20150225000700315F.html>

Kerry F.Khan

АНУ-ын жишээ

- АНУ-ын Армийн инженерийн корпусын худалдан авах ажиллагааны дарга Керри Хан 2013.7.11-нд 19 жил 7 сарын хорих ялаар шийтгүүлэв
- Нийт 15 хүн, 1 компани шийтгэгдсэн
- Холбооны засгийн газрын худалдан авах ажиллагааны түүхэн дэх хамгийн том хэмжээний тендерийн булхайны хэрэг
- Керри Хан дангаараа 12 сая доллар хармаалсан
- 2007-2011 оны хооронд үргэлжилсэн бөгөөд 1 тэрбум долларын гэрээ байгуулахын өмнө баривчилсан
- АНУ-ын Засгийн газарт болон татвар төлөгчдөд 30 сая долларын хохирол учруулсан

□ Эх сурвалж: АНУ-ын Холбооны мөрдөх товчооны хэвлэлийн мэдээ. 2013.7.11, Вашингтон

Тураана, гэхдээ зүрх ГЭМТЭЭНЭ



- Сервиер компанийн Медиатор эм
 - 1976 оноос 2009 оны хүртэл 30 гаран жил
 - Чихрийн шижин өвчинтэй хүмүүст жин хасах зориулалтаар, дараа нь жингээ хасах хүсэлтэй эмэгтэйчүүдэд
 - 1999- 2009 оны хооронд Францын үндэсний эрүүл мэндийн даатгалын сангаас 423 сая евро зарцуулсан
 - 1976- 2009 онд 2000 хүн энэ эмний улмаас нас барсан
 - Шалтгаан –зүрхний хавхлагын гэмтэл
 - Францын ерөнхийлөгч асан Саркози хуульчаар ажилладаг байхдаа тус компанид зөвлөлгөө өгдөг байсан
 - 2009 онд Ерөнхийлөгч Саркози Сервиерт Хүндэт легион гардуулсан
 - Сервиер 2013 он санаатай хүн аллага, авлигын хэрэгт шалгагдаж эхэлсэн
 - 2014 онд 7.7 тэрбум долларын хөрөнгөтэй нас барсан
- Эх сурвалж: Европын холбооны комисс, Эрүүл мэндийн салбар дахь авлигын судалгаа, 2013 он, bbc.com. 2011.1.11; nytimes.com. 2011.12.12; Guardian.co.uk. 2013.1.6; dailymail.co.uk. 2014.4.17;

Эмийн зах зээл

Зах зээл дээр байгаа эмнүүдийн $\frac{3}{4}$ нь анагаах үр нөлөөний талаасаа маш бага, эсвэл ямар ч үр дүнгүй бөгөөд ямар ч хэрэгцээгүй, илүүдэл зүйлс юм.

Бруно Туссон. Анагаах ухааны бие даасан
Прескрипе сэтгүүлийн эрхлэгч

□ Эх сурвалж: bbc.com. 2011.1.11;

Эмийн зах зээл дээр хэрэглэгчдэд ямар ч ашиг тус өгч чадахгүй 800 орчим бүтээгдэхүүн байна.

Филип Евен. Некэр Институтын
ерөнхийлөгч, профессор

Мод тарих төсөл мод огтлох төсөл болсон нь

Хятадын жишээ

- Юннан муж нь Хятадын газар нутгийн 4 хувийг эзэлдэг боловч энэ газар нутагт 16441 төрөл, зүйлийн higher plant (Хятадын 46.8 хувь), 171 төрлийн ховор болон нэн ховор ургамал (хятадын 44 хувь), 1836 зүйл сээр нуруутан (хятадын 55,35 хувь), 243 зүйлийн устах эрсдэл бүхий хамгаалагдсан амьтан (хятадын 72.5 хувь) байдаг бөгөөд эндхийн амьтан ургамлын 20 хувь нь өөр хаана ч байдаггүй.
- Хууль бус мод огтлолт болон бусад шалтгаанаар нутгийн зарим хэсгийн ой устсан.
- 2002 онд Юннан мужийн захиргаа мужийн 3 дүүрэгт нийтдээ 27.5 сая му (1.83 сая гектар) газрыг ойжуулах төсөл хэрэгжүүлэхээр Синар Мас Групп компанитай гэрээ байгуулав.
- Үнэндээ уг 3 дүүрэгт ой модгүй газар үүнээс маш бага буюу 9.7 сая му газар байсан.
- Энэ хэмжээний газарт мод тарихын тулд байгаа модыг нь огтолсон.
- Оронд нь уугуул бус, Австралиас гаралтай евкалипт мод тарьсан.
- Евкалипт их хэмжээгээр тарьснаас хөрсний үржил шим муудсан, гүний усны түвшин багассан, биологийн төрөл зүйл хумигдаж, бичил цаг уур өөрчлөгдсөн.

□ Эх сурвалж: greenpeace.org. 2004; Columbia.edu.2014;

Монголын жишээ

- Гэрчийн мэдүүлэг: Манай Завхан аймгийн нэгдсэн эмнэлэгт Лабтех ХХК-иас 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдөр суурин флюрийн аппаратыг нийлүүлж, 2011 оны 7 дугаар сард суурилуулсан. 2011 оны 7 дугаар сарын 15-наас ажиллуулж эхэлсэн. Нийлүүлэгдсэн цагаас хойш 500 орчим хүний цээжний зураг авсан. 2013 оны 12 дугаар сард уг аппарат тог ирэхээ болиод түүнээс хойш одоог хүртэл огт ажиллаагүй гэжээ.

Эх сурвалж: shuukh.mn, 499 дүгээр шийтгэх тогтоолын 38 дугаар хуудас

“Лабтех”ийн хэрэг

- Гэрчийн мэдүүлэг: Манай Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэгт Лабтех ХХК-аас 2011 оны сүүлээр нүдний хагалгааны микроскоф нийлүүлсэн. Уг микроскопыг суурилуулаад шалгаж үзэхэд хэзээ, хэдэн онд хаана, ямар улсад үйлдвэрлэсэн нь тодорхойгүй, сериал номергүй, овор хэмжээ том, загвар нь хоцрогдсон, үйлчлүүлэгчийн нүүрэн дээр ирэх хэсэг нь маш хүнд байсан болохоор манай эмнэлгийн зүгээс чанарын шаардлага хангахгүй, эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй гэж үзэж хүлээн авахаас татгалзсан. Тэгтэл Лабтех ХХК-ний суурилуулсан инженер нь уг аппаратаа орхиод яваад өгсөн. Уг нь бол аппаратаа суурилуулж өгөөд, шалгалт явуулж, сургалт хийж, хүлээлцсэн акт үйлдэж байж хүлээлгэж өгдөг юм. Уг аппаратыг манайх хүлээн авч акт үйлдээгүй. Тэр цагаас хойш нэг ч хүн үзээгүй, огт ашиглаагүй гэжээ.

Эх сурвалж: www.shuukh.mn, 499 дүгээр шийтгэх тогтоолын 38 дугаар хуудас

Лабтехийн хэрэг

- Мөн Лабтех ХХК-ны нийлүүлсэн тоног төхөрөөмж тухайн байгууллагын тавьсан шаардлага стандартад нийцээгүй авахгүй гэж хэлсээр байхад үндсэндээ хүчээр өгдөг, энэ байдлаас болж одоо ашиглагддаггүй тоног төхөөрөмж сав баглаа боодолтойгоо тухай байгууллага дээр байсаар байгаа, зарим нь огт ашиглагдахгүй байж байгаад устгагдсан, мөн зарим нэг тоног төхөөрөмжийг монголчлох хэлбэрээр засаж сэлбэж ажиллуулдаг байдал хэрэгт авагдсан гэрчүүдийн мэдүүлгүүдээр тогтоогдож байна.

Эх сурвалж: www.shuukh.mn, 449 дүгээр шийтгэх тогтоолын 44 дүгээр хуудас

Лабтехийн хэрэг

- Н.Түмэндэмбэрэл нь Лабтех ХХК-г надтай ямар ч хамааралгүй гэж мэдүүлж байх боловч тус компаний үүсгэн байгуулагч Буян гэгч мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ тухайн үед миний нэр дээр уг компанийг үүсгэн байгуулсан, би 90 хувийг нь эзэмшдэг гэх боловч үндсэндээ надад ямар хамааралгүй, би тухайн үед Н.Түмэндэмбэрэл даргын жолоочоор ажиллаж байсан юм. Тэр үед л миний нэр дээр байгуулсан юм гэсэн мэдүүлгээр, мөн Б.Болорын ... би гүйцэтгэх захирал нэртэй боловч бүх ажлыг Түмэндэмбэрэл зохицуулдаг байсан гэсэн мэдүүлгүүдээр үгүйсгэгдэж байна. Хэрэгт шалгаж байсан баримтуудаас үзэхэд ганц Лабтех ХХК биш өөр олон компаниуд тухайлбал түүний дүү нарын компаниуд тендерт оролцож шалгарч байсан талаар тогтоосон байдаг.

Эх сурвалж: www.shuukh.mn, 499 дүгээр шийтгэх тогтоолын 44 дүгээр хуудас

Авлигын хор хөнөөл Монголд

- Макро түвшинд: Нийгмийн хагарал, баян, ядуугийн ялгаа, нийгмийн тогтворгүй байдал, эдийн засгийн хөгжил зогсох, байгаль орчны доройтол, тусгаар тогтнолоо алдах, хэл, соёлын доройтол
- Месо түвшинд: нийгэм, эдийн засгийн тодорхой салбар уналтад орох, байгууллагууд өөрийн чиг үүргийг гүйцэтгэж чадахгүйд хүрэх,
- Микро түвшинд: хувь хүний ёс суртахууны доройтол, ядуурал, хувь хүмүүсийн хоорондын итгэлцэл бага болдог,


МУ-д цаашид гарч болзошгүй үр дагавар

- Террорист бүлэглэлүүд
 - Гишүүн элсүүлэхдээ тухайн улс орных нь авлига, ялангуяа улс төрийн авлигын нөхцөл байдлыг ашигладаг
 - Өөрсдөө үйл ажиллагаагаа явуулахдаа авлигыг ашигладаг

A chain is only as **strong** as its weakest link



БАЯРЛАЛАА



Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал

© Авлигатай тэмцэх газар, 2018 он

2018 оны эхний хагас жилд Авлигын эрсдэлийн үнэлгээ хийгдэх яам, агентлаг

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
3. Гаалийн ерөнхий газар
4. Татварын ерөнхий газар

1. Хууль зүй, дотоод хэргийн яам
2. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
4. Гадаадын иргэн, харьяатын газар

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
2. Онцгой байдлын ерөнхий газар
3. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
4. Стандарт, хэмжил зүйн газар

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2. Барилга, хот байгуулалтын яам
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
4. Ашигт малтмал, газрын тосны газар

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
2. Зам, тээврийн хөгжлийн яам
3. Эрчим хүчний яам
4. Иргэний нисэхийн ерөнхий газар

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2. Эрүүл мэндийн яам
3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар
4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Байгууллага дахь авлигын нөхцөл байдлыг тодорхойлох үйл ажиллагаа

Төсөөллийн судалгаа

Эрсдлийн үнэлгээ

Шалтгаан, нөхцлийн шинжилгээ

Авлигын эрсдлийн үнэлгээ

Үндэсний хөтөлбөр

- 4.1.1.5-д “**авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх**”.

Авлигын эсрэг хууль

- 6.1.12-т “бүрэн эрхийнхээ хүрээнд **авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийн арилгах**, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах ” үүргийг төрийн байгууллага бүрт оногдуулсан байдаг.

Авлигын эсрэг хууль

- 18.1.1-д “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулах нэгдсэн хөтөлбөр боловсруулах, **арга зүйн удирдлагаар хангах**, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийг АТГ-т оногдуулсан байдаг.

АТГ-ын даргын
тушаал

- 2017 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн А/185 тушаалаар “Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ыг баталсан.

Авлигын эрсдэлийн үнэлгээний зорилго

Тухайн байгууллага дахь авлигын эрсдэлийг илрүүлэх, тогтоох

Авлигын эрсдэлийг бууруулах, арилгахад чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлох

Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ

- Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ нь үнэлгээ хийж буй байгууллагын цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, чадавх, нөөц боломжоос хамааран харилцан адилгүй байна.

Салбар

Байгууллага

Хэлтэс


Алба

Нэгж

- Өөрөөр хэлбэл, энэхүү үнэлгээнд бүхий л салбар, эсхүл байгууллага, байгууллага доторх хэлтэс, алба, нэгж болон тодорхой нэг үйл ажиллагааг үнэлэх боломжтой.

Мэдээллийн эх сурвалж





Эрсдэлийн үнэлгээ зохион байгуулах үе шат

Нөхцөл байдлаа тодорхойлох, төлөвлгөө боловсруулах



Эрсдэл тодорхойлох



Эрсдэлээ үнэлэх: Эрсдэлийн зураглал хийх




Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг тодорхойлох



Үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, хяналт тавих





Хоёр.
Эрсдэл тодорхойлох буюу мэдээлэл цуглуулах.
Үүнд загвар асуулга ашиглаж болно

Гурав. Эрсдлийн зураглал хийх

Risk Rating = Likelihood x Severity

S e v e r i t y	Catastrophic	5	5	10	15	20	25
	Significant	4	4	8	12	16	20
	Moderate	3	3	6	9	12	15
	Low	2	2	4	6	8	10
	Negligible	1	1	2	3	4	5
			1	2	3	4	5
			Improbable	Remote	Occasional	Probable	Frequent
			Likelihood				

Catastrophic	■	STOP
Unacceptable	■	URGENT ACTION
Undesirable	■	ACTION
Acceptable	■	MONITOR
Desirable	■	NO ACTION

4 дүгээр үе шат

- Зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах
 - Хууль тогтоомжид нийцсэн байна
 - Хэрэгжих боломжтой
 - Тодорхой, ойлгомжтой

5 дугаар үе шат

- Зөвлөмжийг хэрэгжүүлэх
- Хэрэгжилтэнд хяналт тавих



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.